

КҮНЗИЙН СОЁЛ СЭТГЭЛГЭЭНИЙ ӨВ ХИЙГЭЭД ЭДҮГЭЭ ЦАГ

М.ЧИМЭДЦЭЭ*

Эдүгээ хүмүүн төрөлхтөн даяаршлын шинэ эрин үед аж төрж байна. Даяаршлын утга учир нь дотносон ойртохын нэр хэмээн эрдэмтэн мэргэд нэгэн дуунаар нотолж байна.

“Хүйтэн дайны” үе эцэс болж, хүж дэлхийн улс гүрнүүд үзэл суртлаараа ялгаран хуваагдаж асан цаг үе нэгэнт түүх болон улирав. Улс гүрнүүдийг тийнхүү үзэл суртлын ялгаа, эдийн засгийн хөгжлийн төвшингээр нь салган хуваах явдал үеэ өнгөрөөж, харин одоо соёл иргэншлээр нь бүлэглэн ангилах болж, соёл иргэншлүүдийн зөрчил, зохирлын асуудал судлаач эрдэмтэдийн туурвил судалгааны гол сэдэв болж байна.

1993 оны зун, АНУ-ын Харвардын Их Сургуулийн профессор Самуэль П. Хантингтон Америкийн улирал тутмын “Гадаад харилцаа” сэтгүүлд “Соёл иргэншлүүдийн мөргөлдөөн үү?” хэмээсэн нэр бүхүй томоохон өгүүлэл нийтлүүлж, энэ сэдвийг анх хөндөж салхийг хагалсан ажээ. Тэрбээр өгүүлэлдээ улс хоорондын харилцааны зөрчил зөрөлдөөнийг цэгнэн дүгнэж, “Хүйтэн дайны” дараах дэлхий ертөнцийн зөрчил мөргөлдөөний эх үүсвэр нь үзэл суртлын ялгаа, эсвэл улс хоорондын эдийн засгийн өрсөлдөөн, улс төрийн эсрэг тэсрэг байр суурь бус, харин шашин шүтлэг, оюун санааны итгэл үнэмшлийг гол цөм болгосон өөр өөр соёл иргэншил хоорондын зөрчил байх болно, ижил буюу төстэй соёл иргэншил бүхүй бүлэглэл буюу улс гүрнүүд ирээдүйд нэгдэн нийлж, ондоо өөр соёл иргэншил бүхүй улс түмнүүд улам холдон тасрах болно хэмээсэн өвөрмөц сонин дүгнэлт хийсэн байна. Түүний үзлээр, ирээдүйд ижил буюу төстэй соёл иргэншлээрээ ойртон нэгдсэн хамтын нийгэмлэгүүд буй болох ажээ.

Эдүгээ судлаач шинжээчдийн тайлбарлаж байгаагаар, хүмүүн төрөлхтөн күнзийн, японы, хиндү, өрнийн, лалын, ортодокс, латин америкийн, африкийн гэх зэрэг хэд хэдэн соёл иргэншилд хуваагдан, тэдгээрийн өөр хоорондын зөрчил зохицлын харилцаагаар ирээдүйн дэлхий ертөнцийн дүр төрх тодорхойлогдох ажээ.

Дэлхий ертөнц даяаршихын зэрэгцээ, соёл иргэншлүүд нэгдэх, салах үйл явц ийнхүү бодитой болж буй энэ цаг үед эртний түүх соёлт Монголчууд тэрхүү соёл иргэншлүүдийн тулгуур үндэс, утга чанар, уг сурвалж, чиг хандлагыг таньж мэдэх нь туйлын чухал буюу. Тэр тусмаа хувь тохиоллын эрхээр хаяа нийлэн айлссан хөрш орнууд - Монгол улс, БНХАУ хоорондын сайн хөршийн харилцан итгэлцсэн түншлэлийн харилцаа улам өргөжин хөгжиж буй энэ үед, ойрын хөрш хятадын уламжлалт соёл иргэншил хийгээд орчин үеийн хөгжлийн чиг хандлагын уялдаа холбоог судалж мэдэх, сурвалжлан таних нь нэн чухал бөлгөө.

Күнз хэмээх нэрийг дурдахуул, хятадын үндэсний уламжлалт соёлын тухай, хятадын үндэсний уламжлалт соёлын тухай ярихуул, Күнзийн гүн ухааны сэтгэлгээ, онол эш, Күнзийн соёл, суртлын тухай дурдах хэрэгтэй болдог билээ.

Тиймийн учир, Күнзийн соёл, гүн ухааны сэтгэлгээний сонгодог бүтээл туурвилаас дуун хөрвүүлэн орчуулж, Күнз гэж хэн болох, Күнзийн гүн ухааны сэтгэлгээ, соёлын язгуур үндэс, уг сурвалж нь юу болох, “Рүшүэ” (Qif) хэмээх Күнзийн сургаал суртал, эш онолын утга чанар, охь дээж нь юу болох, эдүгээ хийгээд ирээдүйн хөгжлийн чиг хандлагатай хэрхэн уялдаж, дэлхий дахинаа хэрхэн түгэн тархаж байнам зэрэг олон асуудлыг сурвалжлан судалж, шинжлэн мөшгиж,

*М.Чимэдцээ. Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, хятад судлаач, орчуулагч, сэтгүүлч

танин мэдэхийн учир холбогдол улам өсч байна.

Күнз болвоос эдүгээгээс 2500 гаруй жилийн тэртээ амьдарч, туурвиж бүтээж асан эртний Хятадын их сэтгэгч, соён гэгээрүүлэгч, сурган хүмүүжүүлэгч, өнөө үед дэлхийн арван их сэтгэгчийн нэг хэмээн цолгорон үнэлэгдэж буй суут их мэргэдийн нэг бөлгөө. Хар багадаа эцэг эхээсээ өнчирч үлдсэн Күнз хорвоогийн хатуу зовлонг хатамжлан туулж, тэр тухайгаа хожим нь “Би хар багаас ядуу доорд явж, хатуу хүтүү бүхнийг сурсан билээ” хэмээн өгүүлсэн байдаг. Тийн зовж зүдэж явсан нь хожим хорвоо ертөнц хийгээд хүмүүний амьдралын жам ёсны түмэн хэлхээ мянган зангилааны учир шалтгааныг олон талаас нь шүүн шинжиж, эш сургаалаа айлдан номлох эх суурь болсон ч байж болох буюу. Тэрбээр тухайн цагийн жаяг журмын дагуу, ёслол, хөгжим, харваа, тэрэг хөтлөх, хэл бичиг, тоо бодлого зэргийг багтаасан “Зургаан эрдэм”-д хичээнгүйлэн суралцаж, “улс эс зарахуйд өөрөө эрдэмд шамдан боловсорсоор”, гучин настайдаа өөрийн номын сургуулиа байгуулан, хэдэн арван жил хичээн зүтгэсээр, шавь нарынх нь тоо 3000 хүрсэн агаад тэдний дотор ном эрдэмд төгс боловсорсон 72 шавьтай байсан тухай түүх шашдирт тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Күнз “Арван годгор борц барьж ирсэн хүмүүнд бичиг эрдэм заахаас эс цааргалан”, “элдэв ялгалгүйгээр эрдэмд сурган”, суртал ёс, эш онол, сургаал номлолоо айлдаж, эрдэмт олон шавь нар нь оюун билиг, ухаан бодрол, цэц мэргэнээ сорин уралдуулж, хожим хүмүүн төрөлхтөний соёл, сэтгэлгээний нэгэн сүмбэр оргил болон мөнхөрсөн Күнзийн суртлын үр тийнхүү боловсорсон түүхтэй юм.

Күнз бүхий л амьдралаа уламжлалт соёлыг сэргээх, сайн ёс суртлыг номлох, түгээн дэлгэрүүлэх, хүн ардыг соён гэгээрүүлэх үйлсэд зориулсан ажгуу. Өтөл насандаа нангиадын соёл, утга зохиолын сор сонгодог зургаан бүтээл болох яруу найргийн “Шүлэглэлт ном”, төр засаглалын “Засагт ном”, гүн ухаан, мэргэ төлгийн “Зурхайт ном”, ёс суртлын “Ёслолт ном”, хөгжмийн “Хөгжимт ном”, түүх шашдирын “Хавар намар” зэргийг эмхэтгэн цуглуулж, ариутган шүүж, туурвин бичиж өвлүүлжээ. Эдгээр бүтээлээс “Хөгжимт ном” нь он

цагийн урсгалд үрэгдэж алга болсон ч, үлдсэн таван бүтээл нь өнөө үед уламжлагдан ирж, хятадын далай их соёл сэтгэлгээний үнэт өв болон хадгалагдаж байх амой.

Күнз итгэлт хэдэн шавиа дагуулан, сайн ёс суртал, шударга засаглал, өршөөл нигүүслийн эрэлд хатан, 7 ханлиг улсаар 14 жил хэрэн хэсүүчилж явахдаа ч, өтөл насандаа ханлиг улсдаа эгэн ирж, соёлын үнэт өвийг туурвин бүтээж суухдаа ч, утга соёл, түүх, гүн ухаан, улс төр, засаглал, нийгэм, ёс суртахуй зэргийг олон талаас нь гүн гүнзгий шинжлэн, үзэл сургаал, эш онолоо айлдан номлосоор “Рүшүэ” хэмээх “Күнзийн сургаал”-ыг цогцлоон буй болгосон түүхтэй бөлгөө. Күнз “Би арван таван наснаасаа эрдэмд шимтэн, гуч хүрэхүйд эрийн цээнд хүрч, дөч хүрэхүйд төөрөлдөж гуйвахааргүй зогсож, тавь хүрэхүйд тэнгэрийн бошгыг таньж, жар хүрэхүйд сонссон болгоноо салгаж ялгаж чадах болж, дал хүрээд хүсэл зоргоороо явавч, хэв ёсны хүрээ хэвчээнээс хэтэрч эс халив.” хэмээн нэгэн насны туулж өнгөрүүлсэн бүхий л амьдралаа хураан өгүүлсэн байдаг. Күнз хийгээд түүний шавь нарын эмхэтгэсэн буюу бичиж туурвисан алдарт “Дөрвөн ном таван бичиг” бүхэлдээ Күнзийн суртал сургаалын үндэс суурь болно.

Ихэд хураангуйлан өгүүлвээс, Күнзийн эш сургаал нь өршөөл элбэрэл, тахимдуу ёсон, ёслол журам, хэв дундыг сахихуй ёсон, ёс суртахуйг эрхэмлэхүй ёсон зэрэг үндсэн хэдэн гол агуулгыг багтаадаг бөлгөө.

ӨРШӨӨЛ ЭНЭРЭЛИЙГ ДЭЭДЛЭХҮЙН УЧИР

Нэгэнтээ гал гарч, Күнзийн морины зүчээ шатжээ. Энэ үед Күнз хааны ордонд бараалхаж байсан аж. Тэрбээр харьж ирээд, гал гарч, морины зүчээ шатсаныг дуулуут яаран асуусан нь:

-Хүмүүн эндэж бэртээгүй буй заа?

Күнз морио ч, эд хөрөнгөө ч эс асууж, харин морь малладаг доорд зарцын бэртэж гэмтсэн эсэхийг лавлажээ.

Күнзийн амьдарч асан тэр харгис бурангуй цагт хамжлага боол хүмүүн адууны зүчээнд сууж, агт морь малладаг байсан нь мэдээж. Тэднийг хүн хэмээн үздэггүй,

ихэнхдээ ярьдаг эд агуурс мэтээр доорд үзэж, эзэд нь дур зоргоороо зарж арилжиж, тэр ч байтугай алж хөнөөж болдог байж.

Тэгвэл Күнз хүнийг дээрд язгууртан, доорд зардсан хэмээн эс алагчлан, хүмүүн хэмээхийн үүднээс адил тэгш үздэг байсныг дээр өгүүлсэн баримт гэрчилнэ. Күнз “Цэргийн жанжны хэргэм зэргийг хурааж болмуй, энгийн хүмүүний хүсэл зоригийг булааж үл чадмой” хэмээн өгүүлсэн байдаг. Энд мөн л эгэл хүмүүнийг эрх тэгш энэрэхүй ёсыг номложээ. Ихээхэн эдүгээчлэн өгүүлвээс, 2500 жилийн тэртээ Күнзийн эш номлолд эдүгээ цагийн хүний эрхийн үзэл санааны үр хөврөл тийнхүү соёолж байсан ажгуу.

Күнзийн сэтгэлгээний гол цөм нь “өршөөл, энэрэл, тахимдуу ёсны” үзэл юм. Тэрбээр айлдвар номлолдоо өршөөл энэрэлийн тухай өгүүлсэн нь маш олон. Тиймээс судлаач эрдэмтэд Күнзийн сургаалын үзэл санааны язгуур үндэс, гол цөм нь өршөөл энэрэл, тахимдуу ёсны тухай үзэл хэмээн үздэг бөлгөө.

Өршөөл энэрэл гэж юу вэ? Күнз үүнийг олон талаас нь өгүүлж, утга агуулга, мөн чанарыг нь өөр өөр байр сууринаас тайлж номложээ. Эзэрхэн дарангуйлагчид эрдэнэт хүмүүний амийг өт хорхойноос дор үздэг бурангуй ёсыг сөргүүлэн, эзэн дээдэс, эгэл олныг эс ялган, эрх тэгш энэрэн хайрлахыг учирлан, “гагцхүү өршөөлт хүмүүн л өөр бусдыг хайрлаж чадах” хэмээн номлож, “хөл хөсөрдөж, самгардахын цагт ч, эд барагдаж, тэнүүчлэхийн цагт ч” өршөөлийг эс умартахын эрхэм чухлыг сургаж байв. Күнз “Хүндлэл, өгөөмөр, итгэл, хичээнгүй, нигүүлсэл” зэргийг “өршөөлт хүмүүний таван шинж” хэмээн зааж, “Өршөөлийн тул ахул өөрийн багшид ч найр талбиж үл болохыг” зөвшөөн, “Эгэл ардад өршөөл ус галнаас илүү эрхэм чухаг бөлгөө. Ус галд хүмүүн орж үхэхийг би үзэв, харин өршөөлийн төлөө үхэхийг эс үзэв” хэмээн халаглан, “Ойрын садангаас өршөөлт хүмүүн дээр” хэмээн номлож байжээ.

Тийнхүү аль тэртээ 2500 жилийн өмнө хүмүүнлэг ёсны эш үзлийг дэвшүүлж байсан бөгөөд тиймээс ч Күнзийг хүмүүнлэг энэрэнгүйн үзэл санааг анх түрүү номлогчдын нэг хэмээн зүй ёсоор үздэг бөлгөө.

Ёс суртахууны талаас нь авч үзвээс, өршөөл энэрэл болвоос бусад хүмүүнийг энэрэн тэтгэх, хүмүүн хоорондын харилцаанд

өршөөл энэрэлийг эрхэмлэх, алив хэрэг үйлд бусдын ашиг тусыг эн тэргүүнд чухалчлан үзэх явдал хэмээн сургасан байна. Күнз “Хайр энэрлийг хамаг олонд хүртээюү, ач тусыг ард олонд түгээюү. ...Өршөөлт хэмээгч нь өөрийн биеийг тэтгэн босгосугай хэмээвээс өөр бусдыг тэтгэюү, өөрийн биеийг аливаад нэвтэрхий болгосугай хэмээвээс өөр бусдыг нэвтэрхий болгоюү, өөрийн биеэр үлгэрлэн ойр адил болгон чадъюү. Энэ бүхнийг өршөөлт ёс хэмээх бөлгөө.” хэмээн номложээ.

Бусдын тусын тулд алив бүхнээ харамгүй зориулах, харин бусдын гаслан зовлон дээр алд биеийн жаргал цэнгэлийг буй болгохыг цээрлэх үзэл Күнзийн номлолд нэвт шингэсэн байдаг.

Күнз гэр бүл, ураг төрлийн хүрээнд эцэг энэрэлтэй, хүү тахимдуу, дүү хүндлэлтэй, ах хайрлалтай, үр хүүхэд эцэг эхдээ ачлалтай тахимдуу, эхнэр нөхөр өөр зуураа эе найртай байхыг номлож, “эцгийн амьд ахуйд зориг санааг нь ажигтун, эцгийг бие барсаны хойно явдал үйлийг нь шинжигтүн, хэрэв эцгийн сургасан ёс журмыг хэдэн жилийн дотор эс зөрчвөөс ачлалт хэмээж болох буюу” хэмээн сургасан бөлгөө.

ЗАСАГЛАХУЙД ЁС СУРТЛЫГ ЭРХЭМЛЭХҮЙН УЧИР

Күнзийн сургаалын нэг гол агуулга бол сайн засаглал, шударга журамт түшмэлийн тухай номлол юм. Күнз сургууль номын газар байгуулан, суртал номлолоо айлдан, соён гэгээрүүлэхийн зэрэгцээ төр засаглалын хэрэгт ч хүчин зүтгэж явсан аж. Тэрбээр “Зэрэг хэргэмийг нь эс эдлэвээс засаглалын хэргийг үл бодох” хэмээн сургаж, “Улс эс зарахуйд улам боловсорсоор” зуугийн талыг наслаад түшмэдийн зиндаанд хүрч, орон нутгийн багшиг түшмэл болж, төдхөн олон ажил сэдэж, ихэд гавъяа байгуулсаны учир Лу улсын шүүх цаазын тэргүүлсэн түшмэлийн албанаа дэвшиж явсан түүхтэй юм.

Күнз хүмүүний амь насыг хөнөөн егүүтгэдэг харгис хатуу засаглалыг эрс шүүмжлэн, эгэл ардыг ч энэрэн хайрладаг өгөөмөр засаглалын төлөө сургаал номлолоо айлдсан байдаг.

Лу улсын нэгэн эрх хэргэмтэн Жи Канзы, Күнзээс улсыг хэрхэн засваас зохилтойг асуун, “Ёс журам үгүйг хөнөөж,

ёс журамтанд шадарлаваас ямар буй?” хэмээхүйд, Күнз “Засаглахын тулд заавал хүмүүн хороохын хэрэг юун? Өөрөө сайн болвоос өргөн олон бас сайн больюу. Эрдэмт сайдын зан үйлдэл салхи мэт, эгэл ардын зан үйлдэл өвс мэт буюу, салхи хаашаа үлээнэ, өвс тийшээ налах бөлгөө” хэмээн хариулсан байна.

Өнөө бидний эшлэх дуртай “Дээд хүн суудлаа олохгүй бол доод хүн гүйдлээ эс олох” тухай зүйрлэлтэй Күнзийн дээр өгүүлсэн номлол утга нэгэн бус уу.

Шударга өгөөмөр засаглал эзэн хаанд ч тустай, эгэл олонд ч тустай хэмээн тэрбээр үзэж байв. “Засаглахуйд ёс суртлыг эрхэм болговоос, алтан гадас мэт буюу. Өөрөө сууринаа бат сууж, үй олон од ямагт тойрон орчих бөлгөө” хэмээсэн сургаал үүнийг бэлхэнээ гэрчилнэ. Күнз эзэн хаан хийгээд эгэл түмэн хоорондын харилцаа, эрхтэн түшмэл хийгээд эгэл олон хоорондын харилцааг алтан гадас одон хийгээд түүнийг тойрон орчих үй олон од эрхсийн хүрээллээр төлөөлүүлэн машид мэргэн цэцэн өгүүлсэн нь энэ бөлгөө. Гагцхүү шударга сайн засаглал тогтоон, эгэл олныг энэрэн хайрлаваас, өргөн олон түмэн эрх баригчдыг үй олон од эрхэс лүгээ адил тойрон хүрээлж, “дээдэс журмыг сахиваас доордос үл дагаж эс зүрхлэх, дээдэс итгэлтэй аваас доордос үнэн сэтгэлээ үл илтгэж эс зүрхлэх “ агаад “өөрийн бие шударгуу байваас зарлиг эс буулгасан ч хэрэг бүтэх, өөрийн бие шударгуу бус аваас зарлиг хэдий буулгавч эгэл олон эс дагахын” учрыг сургасан юм.

Сайн ёс суртал, шударга үнэний эрэлд хатан хэсүүчилж явахдаа “Нарс майлс модод навчисаа хамгийн сүүлд гөвдөгийг тэнгэр хүйтэрч, газар хөлдөхүйд сая анзаардаг аа” хэмээн халаглан өгүүлж, зальхай хуурмаг, зусар бялангач, атаа жөтөө, ашиг хонжоо, авилгач шунахай бүхний уг урхагийг арилгахын язгуур үндэс нь “нэрийг цэгцлэхүйд оршмуй” хэмээн үзэж, “Нэр зөв бус аваас үг хэл эмхгүй болох, үг хэл эмхгүй аваас үйлс хэрэг эс бүтэх, үйлс хэрэг эс бүтэх аваас ёслол хөгжим үл цэцэглэх, ёслол хөгжим эс цэцэглэвээс хууль цааз хөсөрдөх, хууль цааз хөсөрдвөөс эгэл ард эх захаа алдах буюу” хэмээгээд засаглал нь “Хаан хүн хааны ёсоор, сайд хүн сайдын ёсоор, эцэг эцгийн ёсоор, хүү хүүгийн ёсоор байваас” сая шударгуу сайн

засаглал тогтож чадахыг сургасан нь эдүгээ цагийн засаглалын хэрэг явдалд ч бүрнээ хамааралтай юм.

Хүмүүнийг амийг хөнөөн өгүүтгэгч бурангуй засаг, алба гувчуураар алхин дарлагч харгис засаг аль алиныг нь эгэл олны борог амьдралд илт аюул заналтай болохыг тэрбээр сургаж байлаа.

Күнз нэгэнтээ Тай уулнаа гарчээ. Аглаг уулнаа уй гашууд автан, уйлан гаслан суух нэгэн эмэгтэй тааралдахуйд, учрыг лавлаваас, төрсөн хүүг нь дөнгөж сая бар барьж идсэн байжээ. Үүнээс өмнө хүүгийн эцэг, өвөг эцгийг ч аймшигт бар идсэн гэнэ. Күнз гайхан, бар хүмүүнийг барьж иддэг буйд зэлүүд уулнаас зайлж эс холдохын учрыг асуухуйд, “Энд хоргодвоос эрхтэн ноёдын алба гувчуураас ангид хол билээ” хэмээн хариулжээ. Күнз “Харгис засаг махчин бараас илүү хор хөнөөлтэй буюу” хэмээн шүүрс алдан өгүүлсэн гэдэг.

Лу улсад хулгай дээрэм гаарч, улс гэр үймэн самуурахуйд Жи Канзы хэрхвээс зохилтойг хэлж өгөхийг Күнзээс асуужээ. Күнз: “Өөрөө эд агуурст эс шунахайрваас, хөхиүлэн шагнавч бусад хүмүүн эс хулгайлах бөлгөө” хэмээн хариулсан байна.

Иргэн хөлжвөөс улс нь баяжиж, иргэн боловсорвоос улс нь хөгжих жамтай билээ. Энэ жам ёсыг Күнз номлож байжээ. Күнз үнэний эрэлд хатан, хэрэн хэсүүчилж явахдаа нэгэнтээ Вэй улсад хүрчээ. Күнз өгүүллүүн: Эндэхийн хүмүүн энгүй олон ажгуу. Түүний тэргийг хөтөлж явсан шавь Рань Ю өгүүллүүн: Хүмүүн зон олон болохул хэрхвээс зохилтой вэ?

Күнз: Баян чинээлэг болговоос зохилтой.

Рань Ю: Баян чинээлэг болгосоны хойно бас хэрхвээс зохих вэ?

Күнз: Гэгээрүүлэн сургаваас зохилтой.

Күнз ийн номлоод зам мөрөө хөөн цааш одсон гэдэг.

ХЭТРЭХ ДУТУУДАХЫГ ХЭМ ТЭНЦҮҮЛЭХҮЙН УЧИР

Күнзийн нэгэн шавь Зы Гун багшаасаа асууруун: Зы Жан, Зы Шя хоёрын хэн нь илүү мэргэн буй? Күнз өгүүллүүн: Зы Жан болвоос хэтрүүлж, Зы Шя болвоос дутаах бөлгөө.

Зы Гун өгүүллрүүн: Тэгвэл Зы Жан илүү бус уу? Күнз өгүүллрүүн: “Хэтрүүлэх дутаах хоёр хэтдээ адил буюу”.

Күнз алив хэрэг явдалд хөнгөн хуумгай хандан туйлшрахын эсрэг, төв дунджийг нь олохуйн чухлыг номлохдоо, тэрхүү “төв дунджаас” хэтрэн давж, аль нэг тийш хазайж халилгүйгээр, гагцхүү дунджийг нь зөв олж чадваас сая хэрэг үйл төгс бүрэн болж хүмүүний сэтгэлд нийцэхийн учрыг сургасан байдаг.

Гэм хорын үндсийг нь таньж, ямх ямхаар ялган тунгааж, “дунджийг” нь зөв олж чадваас хэрэг үйлийн эсрэг тэсрэг хоёр этгээд эв зохирон нийлж нэгэн цул болохын учрыг Күнз ийн сургасан ажгуу.

“Эгэл жирийн нь эрхэм тансагаас давбаас болхи толхи больюу, Эрхэм тансаг нь эгэл жирийнээс давбаас хоосон хуудам больюу. Эрхэм тансаг хийгээд эгэл жирийн тэгширвээс сая эрдэмт сайд больюу” хэмээн сургасан нь агуулга хийгээд хэлбэрийн нэгдэл зохирлын учир шалтгааныг заасан хэрэг бөлгөө.

Күнзийн “төв дунджийн” тухай эш номлол нь эдүгээ цагийн “хэм хэмжээ” хэмээх ойлголттой ихээхэн дүйж очно. “Төв дундаж” буюу “хэм хэмжээ” нь “хэтэрч хальж” үл болох, бас “дутааж дундарч” үл болох агаад гагцхүү “зохирч тэгшрэх” учиртай ажгуу.

Энэ болвоос Күнз хийгээд Күнзийн сурталтны соёл сэтгэлгээний гол арга бөгөөд үүнийг “Хэв дундыг сахихуй ёсон” хэмээмөй. Күнз “Хэв дундын ёсон болвоос хүмүүний ёс суртлын эрхэм дээд нь” хэмээн үзэж, төр улсын төвшин тайван, түмэн олны амар амгалан, хүмүүн хоорондын харилцааны эв зохирол бүхэн “Хэв дундыг сахихуй ёсон” лугаа амин холбоотой хэмээн сургасан байдаг.

Күнзийн амьдарч асан тэр цагт эзэн хаан хийгээд сайд түшмэдийн өвөр хоорондын харилцааны зохирлоос улс гэрийн оршин тогтнож, мандан бадрах нь ихээхэн хамааралтай байсан ажгуу. Тэр цагт эзэн хаан нь түшмэд сайдаа егүүтгэх, сайд түшмэд нь эзэн хаанаа хөнөөх явдал хэвийн үзэгдэл байжээ. Энэ харилцааг хэрхэн зохицуулваас зохих буй? Күнз хаан сайд хоёр харилцан биесээ хүндлэн, “Хаан сайдыг зарж, сайд хаанд зүтгэх” агаад “хаан сайдыг зарахуйд ёс

журмыг сахиж, сайд хаанд зүтгэхүйд шударга голчийг сахиваас” сая “хэм тэгш” болохыг сургасан байна.

Эрх хэргэмтэн хийгээд эгэл хүмүүн хоорондын харилцааг хэрхэн зохицуулваас зохилтой буй? Эгэл олонд өгөөмөр ууч хандан эрх зоргоор нь тавих уу? Эсбөгөөс эзэрхэг харгис хандан илт дарангуйлах уу? хэмээсэн асуултын хариу Күнзийн эш номлолд тусгалаа олсон байдаг. Жэн улсын тэргүүн сайд Зы Чан хэмээгч нэгэн эрхэм, түшмэл хийгээд эгэл хүмүүн хоорондын харилцаанд “өгөөмөр ууч, эзэрхэг чангын” хэм хэмжээг уран чадварлаг хэрэглэж асныг Күнз ихэд хөхиүлэн магтсан түүх буй. Өгөөмөр хийгээд эзэрхэг хоёрын хэм хэмжээг сайтар зохируулан, “хайрлахуйн зэрэгцээ хатуужуулахуйн чухлыг” сурган, гагцхүү өгөөмөр уучийг дээдлэн, эзэрхэг чангыг орхигдуулваас хамаг олон хууль цаазыг эс хайхрах, бас гагцхүү эзэрхэг хатууг эрхэмлэн, өгөөмөр уучийг орхигдуулваас хүмүүний сэтгэлийг хөсөр гээхийн учрыг номлосон сургаал нь өнөө цагт уламжлан ирэхдээ учир холбогдлоо огхтон ч алдсангүй. Төрийн өгөөмөр бодлого хэдийдвээс эгэл олон цалгар олтгой болох, “төрийн төмөр нүүр” хэтийдвээс түмний сэтгэлийг алдагдуулах гэмтэй агаад өгөөмөр, эзэрхэг хоёр илт зэрэгцэн, хэм тэгширвээс “улс гэр амар түвшин орших учиртайг” тэртээ хэдэн мянганы өмнө тийнхүү номлосон бөлгөө.

“ӨӨРИЙН ҮЛ ХҮСЭХИЙГ ӨРӨӨЛ БУСДАД ЭС ТУЛГАХУЙН” УЧИР

“Өнөөгийн Хятад орон бол шинэтгэл, нээлттэй бодлого хэрэгжүүлж, энх тайвнаар мандан бадарч буй их гүрэн мөн болой”. БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябао 2003 оны 11-р сард АНУ-д айлчлах үеэрээ Харвардын Их Сургуульд зочлон, “Хятад улс лугаа харцаа тусгах нь” хэмээх сэдвээр үг хэлэхдээ ийн тунхагласан юм.

“Энх тайванч мандан бадрал”-ын (和平崛起) үзэл баримтлалын уг чанар, утга санаа, ач холбогдлыг эдүгээ эрдэмтэн судлаачид, улс төрчид олонтаа тайлбарлан таниулж байна.

Чухамдаа өрнө дахинаа олон жил ярьж, улиг домог шахуу болсон “Хятадын аюул

занал” гэгчийн эсрэг дэвшүүлсэн энэхүү шинэ үзэл баримтлалын уг сурвалж нь Хятадын эртний соёлын өв уламжлалаас, тухайлбал, Күнзийн соёл сэтгэлгээнээс эх үндэстэй ажээ. Күнз “дайн хийгээд өвчнөөс цэрвэн болгоомжилж”, “элдэв хачин, эзэрхэг хүч, самуун үймээнийг эс номлодог байсан” хэмээн судар шашдирт тэмдэглэн үлдээсэн байдаг.

Күнз “бусад лугаа санаа зохирон найрамдах, сохроор эс дагалдахуйн” үзлийг номлож, “өөрийн үл хүсэхийг өрөөл бусдад бүү тулгагтун” хэмээн сургасан байдаг. “Алив хүмүүнд хандахуйд эе найртай аваас ёслолд нийцнэ” хэмээн үзэж, “орчлон дэлхийд олон ахан дүүс буй” хэмээн номлосон бөлгөө. Улс гэр оршин тогтнохуйд “хаан хийгээд сайд хүмүүн эд агуурс хомс аваас эс шаналах, ижил тэгш бус аваас шаналах, ард иргэн цөөн аваас эс шаналах, ахуй улс амгалан бус аваас шаналах, эд агуурс ижил тэгш байваас элбэг бус нь юуны хамаа буй, ахуй улс эв найртай байваас ард иргэн цөөн нь юуны хамаа буй, улс гэр амар төвшин оршвоос огтоос хазайх аюул үгүй бус уу” хэмээн сургажээ.

Дээр өгүүлсэн Күнзийн эдгээр эш номлол чухамдаа энэ зуунд улс төр, эдийн засаг, урлаг соёлын зэрэг бүхий л салбарт хүч түрэн, урагш цойлон, хөгжин цэцэглэж буй манай их хөрш орон-БНХАУ-ын дэвшүүлсэн “энх тайванч мандан бадрал”-ын үзэл баримтлалын соёл сэтгэлгээний эх үндэс болж байна. “Алив их гүрэн энх тайванч үйл ажил, үйлдэл төрхөөрөө дэлхий тавцнаа цолгорон тодрох” нь энэхүү үзэл баримтлалын гол цөм, амин сүнс нь юм.

Ерөнхий сайд Вэнь Жябао Харвардын Их Сургууль дээр хэлсэн үгэндээ, “Энх тайванч мандан бадрал”-ын үзэл баримтлал нь хятадын уламжлалт соёл, гүн ухааны сэтгэлгээнээс эх сурвалжтайг дурдаад, “бусад лугаа санаа зохирон найрамдахуй” болвоос

Хятадын эртний их сэтгэгчийн дэвшүүлсэн агуу их үзэл номлол мөн бөгөөд зохирохуй болвоос зэрэгцэн оршиж, жигдрэн хөгжихийн утгыг, эс дагалдахуй болвоос харилцан нөхөлцөж хамтран ажиллахын утгыг илтгэж буйг тайлбарласан байна.

Энх тайванч мандан бадрал”-ын үзэл баримтлал нь олон зууны турш бүрэлдэн тогтож боловсрон хөгжсөөр ирсэн улс хоорондын харилцаанд шинэ тутам үүдэн гарч буй нэгэн жаяг зарчим болох учиртай ажээ. Түүнчлэн эртний их сэтгэгчийн эш онол, соёл уламжлалд бат суурилсан энэхүү үзэл баримтлал нь эдүгээ цаг үеийн олон улсын харилцааны онолд шингэсэн соёлын утга агуулгыг улам тэлэн баяжуулж, тэгснээрээ өөр өөр соёл иргэншлүүд зэрэгцэн оршиж, зохирон зохицох өргөн дэлгэр боломжийг нээж өгнө хэмээн нотолж байна.

“Өнгөрөн одох цаг хугацаа өмнө урсах голын ус лугаа адил өдөр шөнө ер зогсолтгүй” хэмээн Күнз мэргэний сургасанчлан, он цаг урсаж, олон зуун улиран одсон ч, Күнзийн сургаал номлол ер элэгдэж хуучран, баларч мартагдсангүй, харин ч хүмүүн төрөлхтний соёл сэтгэлгээг ийнхүү шинэ өнгө гэрэл, утга агуулга, оюун мэдлэгээр улам бүр тэлэн баяжуулсаар байнам. 1988 оны физикийн салбарын Нобелийн шагналтан, Шведийн нэрт физикч Парис хотноо болсон олон улсын Нобелийн шагналтнуудын хуралдаан дээр, “Хүмүүн төрөлхтөн ирэх зуунд оршин тогтнохыг хүсэж буй бөгөөс, 2500 жилийн өмнө амьдарч асан Күнзийн оюун ухааныг эргэн санаж, өвлөн суралцваас зохилтой” хэмээн нэр дурдан тэмдэглэсэн нь их сэтгэгчийн сургаал номлолын агуу их гүн утга, соёл сэтгэлгээ, амьдрах эрч хүчийг нь, эдүгээ цаг хийгээд ирээдүй хойчид өнө мөнх оршиж улам бүр дэлгэрэх хувь хутгийг нь онцолсон хэрэг мөн буюу.